





# МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИД ДАВХАР БҮРТГҮҮЛЭХ ТУХАЙ

2019.01.25



2018 оны 12 дугаар сарын  
31-ний өдрийн байдлаар




**₮2.5**  
**Их наяд**  
ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

**₮210 тэрбум**

ХУВЬЦААНЫ АРИЛЖАА



**61**  
ГИШҮҮД




— NASDAQ  
— NKY 225  
— FTSE 100  
— MSCI World  
— DJIA  
— Hang Seng  
— MSE TOP-20

TOP-20 ИНДЕКС **21,737.68**


**216**

БҮРТГЭЛТЭЙ КОМПАНИУД



Хамгийн олон IPO: 2018 оны 6 + хүлээгдэж буй 5

Анхны давхар  
бүртгэл:



Анхны байгууллагын  
хөрөнгө оруулагч:



ХИЙГДЭЖ БУЙ АЖЛУУД:

Анхны ХОС-гийн  
нэгж эрх (ETF)-  
ийг бүртгэнэ




ЛХБ, ЕСБХБанкны  
зөвлөмжийн дагуу “Т+2  
төлбөр тооцооны  
систем”-ийг нэвтрүүлнэ



# ҮНЭТ ЦААС ГАРГАСАН КОМПАНИУД

2017	2018			2019	
Q4	Q1	Q2	Q3	Q1	Q2



3 сая \$-оос  
дээш  
(7 тэрбум ₮)



(өндөг үйлдвэрлэл)



ЭРДЭНЭС ТАВАН ТОЛГОЙ  
ERDENES-TT  
(нүүрсний уурхай)



BASALTWOOL  
МОНГОЛБАЗАЛЫТ ХК

(хөвөн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч)

3.1 дахин их  
захиалга



INSURANCE  
SINCE 1994



MANDAL  
insurance

(даатгал)



(хүнсний үйлдвэрлэл)

2 – 3 сая \$  
(5-7 тэрбум ₮)



(финтек-ББСБ)

16.5 дахин их захиалга



(гурил үйлдвэрлэгч)



(ББСБ)

1.2 – 2 сая \$  
(3-5 тэрбум ₮)



(мэдээллийн)

3 дахин их  
захиалга



(хайгуулын үйл ажиллагаа)

Захиалга 66 хувиар давсан

0.4 – 1.2 сая \$  
(1-3 тэрбум ₮)


**Хүлээгдэж буй IPO & SPO:**  
2x Үйлдвэрлэлийн компани  
1x ББСБ

2018 оны 6 сард хамгийн анхны давхар бүртгэлтэй (TSX:ERD) компанийн хувьцааг арилжааллаа.



Бүртгүүлсэн өдөр:	2018.05.23
Арилжаанд оруулсан өдөр:	2018.06.19
Үүсгэн байгуулагдсан улс:	Канад
Үндсэн үйл ажиллагаа явуулж буй улс:	Монгол
Бүртгэгдсэн хувьцааны тоо:	4,000,000
Татан төвлөрүүлсэн хөрөнгийн дүн:	2,494,720,000

Хувьцааны ханш




2018 оны 6 сард хамгийн анхны давхар бүртгэлтэй (TSX:ERD) компанийн хувьцааг арилжааллаа.



Хайгуулын ажил  
хийгдэж буй **ОРОН  
НУТГИЙН ИРГЭДЭД**

**102,000**

ширхэг, **65.3 СЯЯ  
ТӨГРӨГ**ийн үнэ бүхий  
хувьцааг **ҮНЭГҮЙ  
ЭЗЭМШҮҮЛСЭН**




## Төгрөгийн хадгаламж, зээлийн хүү



2018 оны 10 сар:

- Төгрөгийн хадгаламжийн дундаж хүү 12.3%
- Төгрөгийн зээлийн дундаж хүү 18.0%

## Иргэд, аж ахуйн нэгжийн хадгаламжийн үлдэгдэл болон хадгаламжийн хүү





# ҮНЭТ ЦААС ГАРГАХЫН АШИГ ТУС: ХАМГИЙН ХЯМД ӨРТӨГТЭЙ САНХҮҮЖИЛТ

## ЦАГ ХУГАЦАА, ЗАРДЛЫГ ХЭМНЭНЭ:

**ҮНЭТ ЦААС ГАРГАХТАЙ  
ХОЛБОГДОН ГАРАХ** зардлууд,  
үүнд биржийн бүртгэлийн хураамж,  
андеррайтерийн компани, хуулийн  
зөвлөх, аудитийн компанийн  
төлбөр, маркетингийн зардал зэрэг  
**ҮНДСЭН ЗАРДЛУУД НЬ БАНКНЫ  
ЗЭЭЛИЙН ЗАРДАЛТАЙ  
ХАРЬЦУУЛАХАД ХЯМД** байдаг.


Татан Төвлөрүүлэх хөрөнгө	Хувьцаа гаргалтын зардал	vs	Бонд гаргалтын зардал	vs	Зээлийн санхүүжилтийн зардал
5-10 сая \$	0.30-0.55 сая \$		1.01-2 сая \$		1.11-2.22 сая \$
11-25 сая \$	0.60-1.31 сая \$		2.2-4.97 сая \$		2.44-5.54 сая \$
26-50 сая \$	1.36-2.57 сая \$		5.17-9.92 сая \$		5.76-11.08 сая \$

Зээлийн хүүг 22%, Бондын хүүг 17%-иар тус тус тооцов

# ҮНЭТ ЦААС ДАВХАР БҮРТГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ

*Баялаг тэгш хуваарилагдах,  
эрүүл нийгмийн бүтцийг бий болгох үндэс:*

НИЙГМИЙН  
ДАВХАРГА



ХӨРӨНГИЙН ЗАХ  
ЗЭЭЛ


ОРОЛЦОО



ҮР ДҮН



НИЙГМИЙН  
ДАВХАРГА



*Эдийн засгийг хөдөлгөгч гол салбарууд,  
компаниудын хувьцааг ард иргэд эзэмших*

# ҮНЭТ ЦААС ДАВХАР БҮРТГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ

## УЛС ТӨРИЙН БОЛОН ОЛОН НИЙТИЙН ДЭМЖЛЭГ:

Эрсдэл, үр ашгаа  
хуваалцана

## КОМПАНИЙН НЭР ХҮНД

**НЬ** маркетинг,  
сурталчилгааны зардлыг  
бууруулна

## Цаашид ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ НЭМЭГДЭНЭ,

хувьцааны үнэ ханш  
харьцангуй тогтвортой  
байна, хувьцааны хөрвөх  
чадвар сайжирна



## ХӨНГӨВЧИЛСӨН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

- Бүртгэлийн журмын шалгуур,  
шаардлагаас чөлөөлөгдөнө


## СТРАТЕГИЙН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛ:

“Ашигт малтмалын тухай хууль”-д  
заасны дагуу хувьцааныхаа 10-аас  
доошгүй хувийг биржээр  
арилжаалах үүргээ биелүүлнэ

## МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ САЙЖИРНА:

Компанийн талаар олон нийтийн  
мэдлэг, мэдээлэл нэмэгдэнэ & олон  
нийтийн хэвлэл мэдээллийн  
хэрэгслээр мэдээллээ түгээнэ

# САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ЖУРМЫН ХӨНГӨЛӨЛТ



## ГАДААД УЛСЫН АРИЛЖАА ЭРХЛЭХ БАЙГУУЛЛАГАД БҮРТГЭЛТЭЙ ХУУЛИЙН ЭТГЭЭД МОНГОЛ УЛСАД ҮНЭТ ЦААС ГАРГАХ, МОНГОЛ УЛСЫН АРИЛЖАА ЭРХЛЭХ БАЙГУУЛЛАГАД БҮРТГЭЛТЭЙ ХУУЛИЙН ЭТГЭЭД ГАДААД УЛСАД ГАРГАХ ҮНЭТ ЦААСЫГ БҮРТГЭХ ЖУРАМ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээдийн үнэт цаасыг Монгол Улсад гаргах, үнэт цаасыг Санхүүгийн зохицуулах хорооноос нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэл /шашид “Хорооны бүртгэл” гэх/-д бүртгэх, мөн Монгол Улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд гадаад улсад үнэт цаас гаргах, Хороонд бүртгүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээдийн Монгол Улсад гаргах үнэт цаасыг арилжаа эрхлэх байгууллагын арилжаанд оруулахыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэхтэй холбоотой харилцааг тухайн арилжаа эрхлэх байгууллагын үнэт цаасны бүртгэлийн журмаар, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн үнэт цаасны нэгдсэн бүртгэлд бүртгэн хадгалахтай холбоотой харилцааг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий байгууллагын журмаар тус тус зохицуулна.

1.3. Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд нь гадаад улсад гаргасан тодорхой төрлийн суурь үнэт цаасанд тулгуурлан Монгол Улсын хадгаламжийн бичиг гаргах, Монгол Улсад анх гаргасан үнэт цаасанд суурилан гадаад улсын хадгаламжийн бичиг гаргахтай холбоотой харилцааг Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон тусгай журмаар зохицуулна.

1.4. Энэхүү журам нь гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлгүй хуулийн этгээдийн үнэт цаасыг Монгол Улсад анхдагч бүртгэл хийхтэй холбоотой харилцаанд хамаарахгүй.

1.5. Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд нь үнэт цаасаа Хороонд бүртгүүлж, олон нийтэд санал болгосны дараахь үйл ажиллагаатай холбоотой харилцаанд өөрийн харьяалах улс болон үнэт цаасаа бүртгүүлсэн гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагын хууль тогтоомж, дүрэм журмыг дагаж мөрдөх эрх нь нээлттэй байна. Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээдийн үнэт цаасаа анх

*“СЗХ-ны гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд монгол улсад үнэт цаас гаргах, монгол улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд гадаад улсад гаргах үнэт цаасыг бүртгэх журам”*

1.5 Тогтмол үүргийн хэрэгжилтийн хувьд өөрийн харьяалах болон үнэт цаас нь улсын хууль тогтоомжийг мөрдөх эрх нь нээлттэй байна. Хоёр улсын хууль тогтоомжийн хооронд зөрүүтэй байдал үүссэн тохиолдолд гадаад улсын хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдөнө.

4.2.3 Арилжаа эрхлэх байгууллага нь гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээдэд өөрийн үнэт цаасны бүртгэлийн журмын шаардлагаас хөнгөлөх чөлөөлөх эрх нь нээлттэй байна.

4.3.6 Хуулийн этгээд нь өөрийн харьяалах улсын хууль тогтоомж болон арилжаа эрхлэх байгууллагын дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах эрхтэй бөгөөд компанийн засаглалын кодекс, стандарт нэгэн адил хамаарна.

# МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ЖУРМЫН ХӨНГӨЛӨЛТ



## “Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн Үнэт цаасны бүртгэлийн журам”

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

#### 1 дүгээр зүйл. Ерөнхий зүйл

- 1.1 Энэхүү журмаар үнэт цаас гаргагчийн хувьцаа, өрийн хэрэгслийг “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-д “Бирж” гэх/-ийн үнэт цаасны бүртгэл/д “Биржийн бүртгэл” гэх/-д бүртгэх, бүртгэлийн ангилал, шалгуурыг тогтоох, үнэт цаасыг нийтэд танилцуулах, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасалттай холбогдоон харилцааг зохицуулах.
- 1.2 Үнэт цаасыг бүртгүүлэхэд танигдах шаардлага болон бүрдүүлэх баримт бичиг нь тухайн үнэт цаасны төрөл, үнэт цаас гаргагчийн санхүүгийн болон үйл ажиллагааны байдал, үнэт цаасыг гаргах хэлбэрээс хамаарч өөр байж болно.
- 1.3 Энэхүү журмыг Биржийн үнэт цаасны бүртгэлд бүртгэгдсэн, бүртгүүлэхээр хүсэлт гаргасан үнэт цаас гаргагч, тэдгээрийн Төсөөлөн Удирдах Зөвлөл/д “ТУЗ” гэх/-ийн гишүүн, эрх бүхий албан тушаалтан, нөсөө бүхий хувьцаа эзэмшигчид болон андеррайтер, аудитор, хуульч, хөрөнгийн үнэлгэгчид, үнэт цаас гаргахтай холбоотой хөндлөнгийн шинжээч гэрээ мэргэжлийн зөвлөхүүд дагаж мөрдөнө.
- 1.4 Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, хадгаламжийн бичиг гаргах болон бусад үүсгэлт санхүүгийн хэрэгслийг бүртгэлтэй холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулахгүй бөгөөд тусгайлан журмаар зохицуулна.
- 1.5 Гадаад улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй хуулийн этгээд үнэт цаасаа Биржид хоёрдогч бүртгэлээр бүртгүүлж нийтэд арилжаалахтай холбогдоон харилцааг энэ журмаар зохицуулна.

### ХОЁРДУГААР БҮЛЭГ. НИЙТЭД САНАЛ БОЛГОН АНХ УДАА ГАРГАХ ҮНЭТ ЦААСЫГ БИРЖИЙН БҮРТГЭЛД БҮРТГЭХ

#### 2 дугаар зүйл. Бүртгүүлэх ажиллагааны бэлтгэл

- 2.1 Үнэт цаас гаргагч нь Биржийн бүртгэлд бүртгүүлэх бэлтгэл шатанд хуульд заасны дагуу тусгай зөвшөөрөлтэй андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх этгээд /д/ашинд “андеррайтер” гэх/-тэй гэрээ байгуулан бүртгүүлэх ажиллагааны бэлтгэлийг хангана.
- 2.2 Үнэт цаас гаргагч нь Хороонд бүртгэлтэй хуулийн, үнэлгээний болон аудитын үйл ажиллагаа эрхэлдэг зохицуулалттай этгээдтэй гэрээ байгуулан энэ журмын 2.6, 2.7 болон 2.8-д заасан дүгнэлт гаргуулна. Мөн түүвчлэн андеррайтер нь шаардлагатай гэж үнэт компанийн засаглалын асуудлаар дүгнэлт гаргах хөндлөнгийн шинжээчтэй гэрээ байгуулан дүгнэлт гаргуулж болно.
- 2.3 Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй үнэт цаас гаргагчийн хувьд, энэ журмын 2.6, 2.7 болон 2.8-д заасан дүгнэлт нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хууль зүйн зөвлөгөө олох этгээд, хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд болон аудитын үйлчилгээ эрхлэх этгээдээр гаргуулсан дүгнэлт байж болно.
- 2.4 Үнэт цаас гаргагч нь шаардлагатай гэж үнэт Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.8-д зааснаар хөндлөнгийн шинжээч, мэргэжилтэнтэй гэрээ байгуулж үнэлэлт, дүгнэлт гаргуулж болно.
- 2.5 Хуулийн, аудитын, үнэлгээний болон хөндлөнгийн шинжээчийн дүгнэлт гаргах компани нь үнэт цаас гаргагч, андеррайтерийн компанитай болон хоорондоо холбогдох этгээд байхыг хориглоно.

5.4 Гадаад улсын үнэт цаас гаргагч нь энэхүү журам, Биржээс баталсан бусад дүрэм, журам, зааварт заасан тодорхой шаардлагаас хүсэлт гаргасны үндсэн дээр Гүйцэтгэх захирлын тушаалаар чөлөөлөгдөж болно.

7.3 Гадаад улсын үнэт цаас гаргагчийн гаргасан үнэт цаас нь Монгол улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй байх хугацаанд үнэт цаас гаргах хүсэлтэд дурьдсаны дагуу Монгол Улсын хууль тогтоомжид заасан дараах үүргээс чөлөөлөгдөж болох ба өөрийн харьяалах улсын эсвэл анхдагч бүртгэл хийлгэсэн улсын хууль тогтоомжийг дагаж мөрдөх эрхтэй байна. Үүнд:

7.3.1 ТУЗ, түүний бүтэц, хараат бус гишүүдийн тоо, гүйцэтгэх удирдлага зэрэг компанийн бүтэц, удирдлагын тогтолцоо, түүний үйл ажиллагаа, зохион байгуулалттай холбоотой зохицуулалт;

7.3.2 Санхүүгийн тайлан болон санхүүгийн байдлын талаарх мэдээлэлтэй холбоотой зохицуулалт;

7.3.3 Хувьцаа эргүүлэн худалдан авах, тэргүүн ээлжинд худалдан авах болон худалдахтай холбоотой хязгаарлалт бүхий зохицуулалт;

7.3.4 Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах, ногдол ашиг хуваарилахтай холбоотой зохицуулалт;

7.3.5 Нийтэд мэдээлэх үүрэг болгосон бүртгэлийн байнгын үүргүүдтэй холбоотой зохицуулалт;

7.3.6 Их дүнтэй гүйлгээ болон хэлцлийн хэмжээг нарийвчлан заасан зохицуулалт;

7.3.7 Үнэт цаас гаргагч хуулийн этгээд өөрчлөн байгуулагдахтай холбоотой зохицуулалт;

7.3.8 Энэхүү журмын 5.4-т заасан хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлсэн асуудалтай холбоотой зохицуулалт



Петер Акерли,  
Ерөнхийлөгч & Гүйцэтгэх захирал,  
Эрдэнэ ресурс девелопмент корпорейшн



: ERD




: ERDN

*"Being listed on the Mongolian Stock Exchange is a responsible and transparent way of sharing the benefits of any project with the Mongolian public"*

*"Монголын хөрөнгийн биржид үнэт цаасаа бүртгүүлэх нь аливаа төслийн үр ашгийг Монголын ард түмэнтэй хуваалцах хариуцлагатай бөгөөд ил тод арга юм"*

# Анхаарал тавьсанд баярлалаа.



Монголын хөрөнгийн бирж  
Сүхбаатарын талбай- 3, Улаанбаатар хот  
Утас: (976)-11-310 501  
Факс: (976)-11-325 170  
[www.MSE.mn](http://www.MSE.mn)